

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаар:

Зохион байгуулалтын ажлын талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг нэг удаа хийж, 6 асуудал хэлэлцэн, 2 тогтоол гаргаж, 4 асуудлаар тэмдэглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өглөө.

Худалдан авах ажиллагааны 3-р улирлын тайлангийн тухай, улс, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт тавьж буй тухай аймгийн ГХБХБГ-ын даргын мэдээлэл, боловсролын салбарын дэд хөтөлбөрүүд /"Оюунлаг Булган", "Амжилтын галт тэрэг"/-ийн хэрэгжилтийн тухай Нийгмийн бодлогын хэлтсийн даргын мэдээлэл, жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хийж буй ажлын тухай Нийгмийн бодлогын хэлтсийн даргын мэдээлэл, ИТХ-ын шагнал олгох тухай, Тэргүүлэгчдэд урамшуулал олгох тухай зэрэг асуудал хэлэлцэж холбогдох шийдвэр гаргалаа.

Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, төсвийн өөрчлөлтөөр шинэчлэн баталсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг нарийвчлан тооцох, гэрээт хугацаанд нь төсөл арга хэмжээг ашиглалтад оруулахад хяналт тавих, гэрээний хугацаа алдаж байгаа бүтээн байгуулалтын ажлын шалтгаан нөхцлийг тогтоож, арга хэмжээ авах, гадны хандивын хөрөнгийн зарцуулалт, үр ашгийн талаар мэдээлэл өгөх, боловсролын салбарт хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг улам эрчимжүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, жил бүрийн төсөвт тодорхой хэмжээний төсөв тусгах талаар чиглэл өгөв.

Аймгийн ИТХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн XIII хуралдааны материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэв.

Мэдээлэл сурталчилгааны ажлын талаар:

Аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Ажлын албаны үйл ажиллагааны талаар төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байна.

Аймгийн "Сайхан монгол" телевизээр цаг үеийн үйл явдлын талаар сурвалжлага хийлгэж, "Булганы мэдээ" сонинд 15 мэдээлэл нийтлүүлээ. Аймгийн ИТХ-ын байгуулсан гэрээний дагуу Боловсрол, соёл урлагийн газрын үйл ажиллагааны мэдээллийг "Булганы мэдээ" сонинд нийтлүүлээ. "Нутгийн удирдлага" сэтгүүлд аймгийн ИТХ-ын хуралдаан, атрын 60 жилийн ойтой хоолбоотой мэдээ, ярилцлага нийтлүүлэв. Мөн МОНЦАМЭ агентлагт нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны талаар 10 гаруй мэдээлэл дамжуулан үндэсний хэмжээнд сурталчилсан байна.

Тогтвортой амьжиргаа-3 төсөлтэй хамтран "Иргэдийн төсвийн хяналтын бүлэг" байгуулах сургалтыг хийж Булган сумын 6 багийн 18 иргэнийг хамруулсан. "Хяналтын камерын ашиглалт үр дүн" сэдэвт хэлэлцүүлэг, мөн 3-р бүрэн дунд сургуулийн СЭЭБХ-ны гишүүдийн Боловсролын засаглалд эцэг эхийн оролцоо сэдэвт хэлэлцүүлэг хийж 27 хүн хамруулсан.

Авилгагүй нийгмийн төлөө иргэдийн оролцоо төслийн хүрээнд мониторинг хийсэн иргэдийн бүлэг тайлан тавьсан.

Хөдөө ажилласан тухай:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын батласан удирдамжаар 3 чиглэлээр сумдад ажиллалаа. Үүнд:

- Уул, уурхайн чиглэлээр Бүрэгхангай, Дашинчилэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай танилцлаа. Тус ажлын хэсэгт аймгийн ЦГ, МХГ, ТХ, БОАЖГ, ГХБХБГ-аас холбогдох мэргэжилтэнүүдийг хамруулан уул уурхайн бодлого, чиглэл гаргахад тэргүүлэгчид, төлөөлөгчдийг мэдээллээр хангах нөхцөл байдалд дүгнэлт хийх зорилгоор ажилласан. Ажлын хэсэг дүнг аймгийн ИТХТ-эд танилцуулж ажиллана.
- Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр, Баян-Агт, Сайхан, Бугат суманд хийгдсэн төсөл арга хэмжээний хэрэгжилттэй танилцлаа. Уг ажлын хэсэгт аймгийн ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ-аас холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулж батласан төсөл арга хэмжээ хэрхэн зүй зохистой хэрэгжиж байгаа нөхцөл байдалтай танилцлаа.
- Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа Дулаан дамжуулах станц, “Булган Мээж” ОНӨК-ий хамтын үйл ажиллагаа, өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор ажлын хэсэг ажиллалаа.

Хяналт-шалгалтын тухай:

- Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх хэлтсээс соён гэгээрүүлэх, хууль хяналтын байгууллагын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж ИТХ-ын Тэргүүлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан.

Дотоод ажил:

- Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд аймгийн ИТХТ-ийн ажлын албанд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулж ажиллаа.
- Могод сумын ИТХ-ын төлөөлөгчидөд сургалт хийх, арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллалаа

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Төрийн захиргааны ажлын чиглэрээр:

Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригоор ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Булган аймагт ажиллаж, 230 төрийн албан хаагчдад “Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх нь” нэгдсэн сургалтыг зохион байгууллаа. Баяннуур, Дашинчилэн сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Онцгой байдлын газар, Биеийн тамир спортын газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцлаа. Мөн төрийн албанд ажиллаж байсан ахмад үеийн төлөөллүүдтэй уулзаж төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар санал, зөвлөгөөг нь сонслоо.

Төрийн албаны ерөнхий шалгалтын цахим бүртгэлийг 2019 оны 10 дугаар сарын 1-31-ний өдрүүдэд зохион байгууллаа. 10 дугаар сарын 31-ний байдлаар Булган аймагт ерөнхий шалгалтад оролцохоор 174 иргэн бүртгүүлээд байна.

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ энэ оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн үзэл санаанд нийцүүлэн аймгийн ИТХ, ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 7 агентлагийн 135 төрийн жинхэнэ албан тушаалын 104 тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан, батлан зөвшөөрлийг авлаа. Батлахыг зөвшөөрсөн албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулан, хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлээд байна.

Гадаад харилцааны чиглэлээр:

Аймгийн Засаг дарга З.Батзоригийн урилгаар Япон улсаас Монгол улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд М.Такаока манай аймагт айлчиллаа. Тус айлчлалын хүрээнд "Өвсний үндэс-Хүнсний аюулгүй байдлыг хангах буцалтгүй

тусламжийн хөтөлбөр"-ийн хүрээнд "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн гадна засварын ажлыг санхүүжүүлэх 231.2 сая төгрөгийн гэрээнд гарын үсэг зурлаа.

Аймгийн Засаг дарга З.Батзоригийн тавьсан хүсэлтийн дагуу Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөртэй манай аймаг хамтын ажиллагаа эхлүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 1 аймагт жилд дунджаар 140 мянган еврог /420 сая төгрөг/ жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулж буцалтгүй хэлбэрээр санхүүжүүлдэг бөгөөд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод бүх талын уялдаа холбоог тэгш хүртээмжтэй хүргэж хэрэгжүүлдгээрээ онцлогтой юм.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр:

"Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн 2019 оны 03 дугаар улирлын хэрэгжилтийг 79.1 хувийн биелэлттэйгээр "Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан"-д байршуулж, цаасаар ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээ тайлан ирүүлэх тухай аймгийн Засаг даргын 2019.10.08-ны өдрийн 01/1275 дугаар албан тоотыг сум, агентлагийн дарга нарт хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийн 2019 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн тайланг бүртгэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Аймгийн ИТХ, ИТХТ-ийн гаргасан тогтоол шийдвэрийн биелэлт, аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар ирүүлэх жагсаалтыг үйлдэж сум, байгууллагуудад хүргүүлээд байна.

2019 оны 10 дугаар сарын байдлаар Засгийн газрын 3 тогтоол, 2 хуралдааны тэмдэглэл ирснийг хяналтад авч аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцууллаа.

ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хууль зүйн сайдын эрхлэх хүрээний агентлагууд болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх, зүйн хэлтсээс 2019 оны 10 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/204 тоот тушаалаар Булган аймгийн Хууль, эрх зүйн хэлтэс, Архивын тасаг, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, /Орхон сум дахь 439 дүгээр хаалттай хорих анги/, Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба, Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд 7 чиглэлээр хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх зорилгоор ХЗДХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Н.Жавхлантагсөөр ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Булган аймагт ажилласан.

Авилгатай тэмцэх газрын ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр 02-ны өдрүүдэд Булган аймагт ажиллахтай холбогдуулан "Авилгагүй нийгмийг бүтээхэд иргэдийн оролцоо" сэдэвт 7 хоногийн аян зохион байгуулсан. Аяны хүрээнд аймгийн ГХУСА33-тэй хамтран "Авилгагүй Булганы төлөө" сэдэвт дэвжээ тэмцээнийг Булган сумын 6 багийн иргэдийг оролцуулан зохион байгуулсан.

Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 10 дугаар сард 5 сумын Засаг даргын 103 захирамж, Тамгын даргын 54 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллалаа.

Иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн 2 мэдэгдлийн хариуг хугацаанд нь явуулсан.

Хугацаатай 7 бичгийн хариуг ирүүлсэн чиглэлийн дагуу ажлуудыг хийж гүйцэтгэн заасан хугацаанаас өмнө хүргүүлсэн.

Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилтын хүрээнд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөр 12 хэргийн 12

холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээ үзүүлэн 10 иргэнд хуулийн зөвлөгөө өгч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын байдлаар 418 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 134 хэргээр буюу 47.2 хувиар өссөн байна. Зөрчлийн улмаас нийт 594 хүн эрүүлжүүлэгдэн 216 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж, торгуулсан 218 хүн бүртгэгдсэн байна.

Бүрэгхангай, Булган, Тэшиг, Хялганат тосгонд буурч, бусад суманд өссөн дүнтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын чиглэлээр 10 дугаар сард хорихоос өөр төрлийн ял шийтгэл эдэлсэн иргэдээс торгох ялын 31 гүйцэтгэх хуудасны 149.249 .200 төгрөгийн үлдэгдэлтэй, нийтэд тустай ажил хийлгэх ялын 6 гүйцэтгэх хуудасны 950 цагийн үлдэгдэлтэй, эрх хасах ялын 14 гүйцэтгэх хуудасны 7481 хоногийн үлдэгдэлтэй байна. Албадлагын арга хэмжээ авсан тэнссэн 54 иргэн түүнээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан 29, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 5, хөрөнгө орлого хураах 3, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 3 иргэн байна.

Улсын бүртгэлийн чиглэлээр 10 сард Төрөлт-97, Нас баралт-25, Гэрлэлт-27, Овог нэр өөрчлөлт-4, Үрчлэлт-2, Гадаад паспорт захиалга-43, Лавлагаа-264, Иргэний үнэмлэх захиалга-67, Шилжилт хөдөлгөөн-392 Үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл-23, орон сууц бэлэглэх гэрээ-1, төрөөс үнэгүй хувьчилсан өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт-48, гэрээний эрхийн бүртгэл-123, Барьцааны гэрээ-3, Шинэ бүртгэл-5, нэмэлт өөрчлөлт-3, лавлагаа-8, татан буугдсан-2, тамга, тэмдэг-3 үйлчилгээ хийгдсэн байна.

Шүүх шинжилгээний албаны чиглэлээр 10 сард нийт 37 хэргийн газрын үзлэгт оролцон 1720 кадр гэрэл зургаар ул мөр бэхжүүлсэн. Илрүүлсэн гарын мөр 5, гутлын мөр 12, тээврийн хэрэгслийн мөр 15, бусад ул мөр, эд мөрийн баримт 18, нийт 50 ул мөр илрүүлж, ажилласан байна. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр кримналистикийн 4, цогцост 12, гэмтлийн зэрэг тогтоох 43, химийн шинжилгээ 8 хийж, папилон санд 16 иргэний гарын хээг оруулсан байна.

Төрийн архивын чиглэлээр:

Энэ сард лавлагаа авахыг хүссэн 113 нийт иргэнд 626 /давхардсан тоогоор/ баримтаар үйлчилсэн. Цахимаас 15 иргэнд тушаалын лавлагаа олгов. Тушаалын 266, цалин 360 баримтаар үйлчилсэн. 84 иргэнд хуулбарын лавлагаа олгож, 50 иргэнд цалингийн баримт, 10 иргэнд тодорхойлолт олгосон.

Архивын тасгийн 9 сарын лавлагааны материалыг үдэж хавтасласан. Мөн хөмрөг үүсгэгч байгууллагын баримтын тоо хэмжээ хадгалалтын байдлын мэдээг нэгтгэж ирүүлэх талаар албан байгууллага, сумдад хугацаатай албан тоот хүргүүлэв.

ГУРАВ: БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Боловсрол, соёл урлагийн чиглэлээр:

- БСУГазар үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд “Байгууллагын менежмент-багшийн хөгжил-сургалтын чанар” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан.
- Боловсрол, соёл урлагийн газрын үүсч хөгжсөний 60 жил, багш нарыг баярыг тохиолдуулан “Боловсрол-60” баярын хурал, хүндэтгэлийн концертыг амжилттай зохион байгууллаа.
- Орхон сумын ЕБС-ийн гадаад хэлний багш, сурагчдаас авах шалгалтын материалыг боловсруулсан.

- Улаанбаатар хотод болох “Бага насны хүүхдийг хүчирхийллээс ангид орчинд дэмжих нь сургалт”-д СӨБ хариуцсан мэргэжилтэн Н.Мөнхтуяа оролцсон.
- “Хандлагаа өөрчилье-Тэгш оролцье” сэдэвт хэлэлцүүлэгт сургуулиудын нийгмийн ажилтнууд оролцлоо.
- Орхон сумын гадаад хэлний багш, сурагчдаас авах шалгалтын сэдэв боловсруулав.
- Орхон аймагт болсон “Хамтарсан багийн чадваржуулах бүсийн сургалт”-д хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн оролцоод ирлээ.
- Математикийн хичээлээр олимпиад уралдаанд оролцдог сурагчдаас сонгон авч II улирлаас Олонлог, I, XI сургуулиуд дээр сургалтад хамруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 23 дугаар тогтоол “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 15 дугаар тогтоол “Ахмадын хөгжлийг дэмжих жил”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Ахмадын баяр”-ын тохиолдуулан байгууллагын ахмадуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулав.

Аймгийн засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн “Эрүүл мэнд” зорилтод тусгагдсан “Нүүдлийн амбулаторийн үзлэг”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, орон нутагт тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг”-ийг Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран Хялганат тосгонд 2019 оны 10 сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд зөөврийн рентген, бэлгийн замаар дамжих халдвар, лаборатори, сүрьеэ, хүүхэд, мэдрэл, дотор, эмэгтэйчүүд, нүд, шүд, хавдар, мэс засал зэрэг нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээг хийж, эрүүл мэндийн сургалт сурталчилгаа зохион байгуулсан.

Үзлэгт нийт 256 иргэнийг хамруулан, халдварт болон халдварт бус өвчлөл илэрсэн иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх, эмчийн хяналтанд авах, дараагийн шатлалд шилжүүлэх зэрэг ажлуудыг хийсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Гэмтлийн тасгийн засварын ажил бүрэн хийгдэж дууссан.

Бугат суманд малын гоц халдварт боом өвчин гарсантай холбогдуулан сумын Засаг дарга Х.Ууганбаярт 2019 оны 10 сарын 03-ны өдрийн 02/206 тоот зөвлөмжийг хүргүүлж, голомтын бүст хөл хорио тогтоож, бүс нутгийн иргэдийн эрүүл мэндийн хяналтыг зохион байгуулж, халдваргүйтгэл, ариутгалын үйл ажиллагааг тогтмол хийж ажилласан.

ГССҮТ, “Монос” ХХК-тай хамтран “Осол гэмтлийн үед үзүүлэх яаралтай тусламжийн үеийн менежмент” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламж, мэс засал, гэмтлийн эмч, сувилагч нийт 62 эмнэлгийн ажилтныг хамруулсан.

Гурванбулаг, Бугат сумдад шинэ томуугийн халдвараас сэргийлэх, томуугийн сэжигтэй тохиолдлыг эмчлэн эрүүлжүүлэх, эмнэлэг дэлгэх, үзүүлэх сургуулийг зохион байгуулж, сумын онцгой комиссын гишүүд болон мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, эмч, эмнэлгийн ажилчид нийт 162 хүнийг үзүүлэх сургуульд хамруулсан.

Гар, хөл амны халдварт өвчин, томуугийн вакцины тухай ойлголт, боом өвчны тухай мэдээ, мэдээллийг 2 удаа давхардсан тоогоор 126 албан хаагчдад хүргэсэн.

“Хоол үйлдвэрлэлд шинэлэг хандлага нэвтрүүлэх нь” нэрэмжит сарын аяны хүрээнд аймгийн “Тогооч нарын холбоо”-той хамтран эрүүл мэндийн байгууллагуудын тогооч, нярав Булган сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, үдийн цай бэлтгэн нийлүүлэгч аж ахуй нэгжүүдийн нийт 66 тогооч, нярвуудад “Хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл хадгалалт, боловсруулалт, эрүүл ахуй

болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх нь” сургалтыг 2019 оны 10 сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулсан.

“2019 оны төсвийн гүйцэтгэл, онцгой анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт зохион байгуулж, 32 албан хаагчид хамрагдсан.

ХӨСҮТ, АШУҮИС-тай хамтран “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”, “Тэмбүүг устгая” аяны үйл ажиллагааны хүрээнд “Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах нь” сэдэвт сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын их эмч, Нэгдсэн эмнэлгийн БЗДХ кабинетийн их эмч, сувилагч, эх барих эмэгтэйчүүдийн тасгийн их эмч, сайн дурын зөвлөгөө шинжилгээний бага эмч, ЭМГ-ын асуудал хариуцсан мэргэжилтэнг хамруулан зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 2019 оны тайлан болон 2016-2019 оны тайланг нэгдсэн байдлаар гарган хугацаанд нь хүргүүлсэн.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 97 дугаар зарлигаар аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр”-өөр аймгийн Эрүүл мэндийн газар, өрхийн ЭМТ-үүд, Нэгдсэн эмнэлэг, эмийн сан зэрэг байгууллагууд иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж, 91 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэн, 17 иргэнийг дотор, эмэгтэйчүүд, дүрс оношлогооны чиглэлээр нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан зөвлөгөө зөвлөмж өгч, байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр 95 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч, 15 нэр төрлийн гарын авлага, сурталчилгааны материалыг 90 гаруй иргэдэд түгээж санал солилцож ажилласан.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг Хишиг-Өндөр, Рашаант, Гурванбулаг, Могод, Хутаг-Өндөр, Тэшиг зэрэг сумдад зохион байгуулж, ЕБС-ын ахлах ангийн сурагчид 404, ажилгүй иргэд, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 162 иргэнийг хамруулав. Бүлгийн сургалтаар нийт 566 иргэнийг хамруулаад байна.

Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн 35 ажилтанд “Мэргэжлийн харилцаа”, Булган сумын ЗДТГ-ын 43 ажилтанд Хөдөлмөрийн бүтээмж, чанарын дугуйлан сэдвээр сургалт зохион байгуулав.

Нэг цонхны үйлчилгээгээр давхардсан тоогоор 30 гаруй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн чиглэл болон ажил хайгч иргэн ажилд зуучлах үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 596 иргэн идэвхтэй ажил хайгч иргэн бүртгэлтэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн бага буюу боловсролгүй иргэд 18 хувь, бүрэн дунд боловсролтой 45 хувь, дипломын болон бакалаврын дээд боловсролтой 13 хувь, тусгай болон техникийн мэргэжилтэй 7,6 хувийг эзэлж байна. Нийт иргэдийн 85 хувийг 25-54 насныхан эзэлж байна.

Ажил олгогч 25 байгууллагаас ажлын байрны захиалга авч, орон нутгийн телевиз болон зарын цэгүүдээр байршуулан зар сурталчилгааг явуулж, 192 иргэнийг ажлын байраар хангасан бөгөөд байнгын ажлын байранд 27 иргэн, улирлын ажлын байранд 46 иргэн, түр ажлын байранд 119 иргэдийг зуучиллаа.

Төр, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч 75 байгууллагаас 132 ажлын байрны захиалгыг хүлээн авч “Ажил хийх хүсэлтэй хүн бүхэнд ажлын байр байдаг” уриатай ажлын байрны өдөрлөг зохион байгуулсан бөгөөд энэхүү арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар Өрхийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, ХХҮГ-т мэргэжилтэн 1, Сэлэнгэ сумын “Ингэт толгой” ХХК-д нягтлан бодогч 2, тракторын жолооч 4, жолооч 4, иргэн н.Батдорж малчин 1, “Булган кашмер” оёдлын үйлдвэр

оёдолчин 1, зэрэг 4 ажил олгогчоос 13 ажлын байрны захиалгыг хүлээн авч, орон нутгийн “Сайхан монгол” телевизээр олон нийтэд мэдээлж, сурталчлах ажил хийгдсэн.

Ажил хайгчаар шинээр бүртгүүлэх болон идэвхжүүлэх хөдөлгөөнд 29 иргэнийг бүртгэж, Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд 37 иргэнд, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн талаар 18 иргэнд зөвлөгөө мэдээлэл өглөө. Ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг 12 иргэнд гаргаж, нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн талаар ажил эрчимжүүлж зөвлөн туслах чиглэлээр Тэшиг суманд 12 аж ахуй нэгж байгууллагын 84 ажлын байрны захиалгыг бүртгэж, Малчдын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэнд мал худалдан авч, хүлээлгэн өглөө.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ирсэн албан бичгийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017-2018 оны баримтуудыг шалгаж байгаатай холбоотой мэргэжлийн хяналтын улсын байцаагчид холбогдох мэдээ судалгаануудыг гарган өгч, 2016-2018 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн шалгалтаар МХЕГ, Аудитын байгууллага, ХХҮЕГ-ын хяналт мониторингийн газраас өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт болон ХЭДС-ийн 9-р сарын мэдээг гарган баталгаажуулж ХХҮЕГ-т хүргүүлсэн.

Тус газрын байранд ус алдсантай холбоотой усанд норсон Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Могод сумдын халамжийн сангийн материалыг эмхэлж, дутуу баримтыг бүртгэлээ.

“Намрын ногоон өдрүүд-Булганд үйлдвэрлэв” хөдөлмөрийн яармаг, үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, уг арга хэмжээний үеэр 77 иргэн, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудаас 138 ажлын байрны захиалгыг авч, 11 иргэнийг байнгын ажлын байранд зуучлан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн гарын авлага, мэдээ мэдээллийг 138 иргэнд өгч, сурталчилгаа хийсэн.

Үзэсгэлэн худалдаанд 12 сумын 46 иргэн аж ахуй нэгжийн 138 нэр төрлийн бүтээгдэхүүний үзэсгэлэн гарган Булган сумын ард иргэдэд худалдан борлуулж байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Баян-Агт, Баяннуур сумдын нийтийг хамарсан ажлын гүйцэтгэлийг, мөн Зохион байгуулалттайгаар ажлын байр бий болгох арга хэмжээний хүрээнд Хангал сумын ажлын гүйцэтгэлийг тус тус хүлээн авч, ажлын хөлсийг олгосон. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдахаар иргэдээс ирүүлсэн төслүүдийг ажлын хэсгийн хурлаар сонгон шалгаруулж 10 сумын 13 иргэний төслийг 53 сая төгрөгөөр дэмжлээ.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдсан 9 ахмадад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн урамшуулал 2,5 сая төгрөгийг, Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Орхон суманд хийгдсэн “Ногоон байгууламж”, “Сээр, Шувуутын гол дагуу хог цэвэрлэх” төслийн санхүүжилт 5,6 сая төгрөгийг, Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн Зохион байгуулалттайгаар ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдсан иргэдийн урамшуулал 500,0 мянган төгрөгийг тус тус олгосон. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдахаар иргэдээс ирүүлсэн төслүүдийг авч дууссан. Нийт 60,7 сая төгрөгийн 15 төсөл ирсэн байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бүтэн өнчин хүүхэд, өрх толгойлсон эх, нэн ядуу амьдралтай иргэдэд Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн дараах үйлчилгээнүүдийг үзүүлээд байна. Үүнд:

- Халамжийн тэтгэвэр 1047 иргэнд 1.482,5 сая.төг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 1429 иргэнд 884,0 сая.төг

- Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж 1375 иргэнд 463,7 сая.төг
- Ахмад настан 983 иргэнд 274,8 сая.төг
- Хөгжлийн бэрхшээлтэй 184 иргэнд 68,6 сая.төг
- ЖХЭТэтгэмж 1081 иргэнд 157,1 сая.төг
- Хүнс тэжээлийн дэмжлэг 4936 иргэнд 313,8 сая.төг
- Эхийн алдар I, II зэргийн одонтой 5525 эхчүүдэд 722,7 сая.төг
- АЦАТэтгэмж 33 ахмадад 43,0 сая.төг
- Насны хишиг 3142 ахмадад 483,0 сая.төг
- Цалинтай ээжийн тэтгэмж 3243 эхэд 1.139,7 сая
- Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжид 94 иргэнд 78.7 сая.төгрөгийг тус тус зарцуулсан.

Халамжийн сангийн 2019 оны 10-р сарын санхүүжилтийг хийж, мөнгийг олгож байна. Мөн 7, 8-р сард хүнс олгосон дэлгүүрүүдтэй тооцоо хийж, хүнсний мөнгийг олголоо. Шилэн данс болон цахим санхүүгийн тайланг шивж явуулсан. Тухайн сарын мэдээ тайлан судалгааг ХХҮЕГ, Төрийн сан, Статистикийн хэлтэст хугацаанд нь гаргаж хүргүүллээ.

Өрхийн мэдээллийн санд шинэ төрсөн 134, овог нэрээ өөрчилсөн 4, нийт 138 хүүхэд бүртгүүлсэн байна.

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан 26 өрхийн судалгааг мэдээллийн санд шивж орууллаа.

2019 оны 10 дугаар сарын байдлаар 885 өрхийн 2392 том хүн, 2174 хүүхэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Хишиг-Өндөр, Рашаант, Гурванбулаг, Могод сумдын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 29 өрхөөр зочилж хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлдэг дэлгүүрүүдээр орж, “Өрхийн үнэлгээний хуудас”-аар өрхийг үнэлэн, 9 өрхийн 14 иргэний хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түдгэлзүүллээ.

Булган сумын цахим эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 323 өрхийн 10 сарын гүйлгээг хийж, цахим эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлдэг 4 дэлгүүрт жагсаалтыг хүргүүлэн хүнсийг олгож, хувийн хэрэгт тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

10 дугаар сарын цаасан эрхийн бичгийг сумдад хүргүүлж байна. Мөн сумдаас сар бүр олголт, хөдөлгөөний мэдээг хүлээн авч программд оруулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд үнэмлэх өгч, нийгмийн халамжийн тэтгэвэрт 7 хүн орсон байна. Нийгмийн халамжийн сангаас 695 хөгжлийн бэрхшээлтэй иргэн протез, ортопедийн хөнгөлөлт эдэлж, 961,8 сая.төгрөгийн дэмжлэг авсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 5 иргэн хамрагдаж, эхний үйл ажиллагаагаа явуулж тайланг аваад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 19 удаа хурал хийж, 142 хүүхдийг хуралдаанаар оруулж, 38 хүүхдэд байнгын асаргаа шаардлагатай болохыг тодорхойлж, 66 хүүхдийн байнгын асаргаа шаардлагатай хугацааг сунгав. Насанд хүрсэн 1, тухайн хүүхдийн онош байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалтад байхгүй 9, байнгын асаргааг цуцалсан 4, биеийн байдал сайжирсан 3, онош тодруулахаар буцаагдсан 4, хөгжлийн бэрхшээл сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 27, ерөнхий боловсролын сургуульд 40, боловсролын үйлчилгээнд 3, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд 2, тусгай сургуульд 5 хамрагдсан байна. Хурлаар орж байгаа хүүхэд болон асран хамгаалагч нарт нь эмчийн үзлэгт тогтмол хамруулж байх, хөдөлгөөн засах болон сэргээн засах үйлчилгээг хийж байх, сургууль, цэцэрлэгт болон хөгжлийн төвд хамруулах, холбон зуучлах, нийгмийн халамжийн үйлчилгээ хэрхэн авч байх талаар мэдээллийг тухай бүрд нь өгдөг. Салбар комиссын 3-р улирлын тайланг төв комисст хүргүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил оролцоог дэмжих, тэдний санал хүсэлтийг сонсох, салбарын байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хүүхдийн саналыг бодлого шийдвэрт тусгах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн уулзалт зөвлөгөөнийг 2 жил тутам зохион байгуулдаг. Энэ жил 10 сарын 08-ны өдөр төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан, сум бүрээс хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхэд, нийгмийн ажилтан, асран хамгаалагч нарын дуу хоолойг сонсож, тэдний дунд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, нийгмийн хөгжил оролцоог сайжруулж, эрүүл мэндийн анхан шатны үзлэг оношилгоонд хамруулах өдөрлөг зохион байгуулсан бөгөөд 200 гаруй иргэд хамрагдлаа. Энэ уулзалтад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комиссын хурлаар орж байгаа хүүхдийн талаар мэдээлэл бэлтгэж танилцууллаа.

Хууль эрх зүйн сурталчилгаа, мэдээллийг тогтмолжуулах зорилгоор Зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах өдрүүдээр бодитой ажил зохион байгуулан ажиллаж байна. Цагаан сар, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, олон улсын гэр бүлийн өдөр, хүүхдийн баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээг хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд: гэр бүл, сургуулийн насны хүүхдүүдийн дунд болон насны бүлгээр уралдаан тэмцээн зохиох, захиа бичих, ахмадад туслах, дуулж бүжиглэх, АХА тэмцээн зохиох, музей үзүүлэх, хөгжөөнт буухиа зэрэг 27 төрлийн тэмцээн уралдаан, танин мэдэхүйн арга хэмжээ авч, 3715 иргэн хамрагдсан байна.

Эмэгтэйчүүдийн эхо, дотоод шүүрэл, зүрхний бичлэгийн үзлэгт, умайн хорт хавдрын үзлэг оношлогоо, эмэгтэйчүүдийн үзлэг, шүдний сувган эмчилгээ, шүд авах, даралт үзэх, сүрьеэ, эрүүл мэндийн ерөнхий үзлэг, оношлогоо хийх зэрэг үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээнд 2106 зорилтот өрхийн гишүүдийг хамруулсан байна. Төлөвлөгөөний дагуу хамтарсан баг, холбогдох байгууллагын дэмжлэгтэйгээр 291 өрхөд өөрчлөлт гарч, амьжиргааны түвшин өөрчлөгдсөн гэж үнэлж байна.

Өрх толгойлсон эцэг, эх аймгийн хэмжээнд 1147 байгаа бөгөөд 281 эцэг, 857 эх байна. Нийгмийн халамжийн тэтгэмжийн 3 ба түүнээс дээш тооны 18 хүртэлх насны хүүхэдтэй 87 эцэг, эх байна. Зорилтот бүлгийн өрх, иргэдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 87 эцэг, эхэд 27205.3 сая.төгрөгийг зарцуулсан.

Халамжийн сангаас 9-р сарын байдлаар 23216 иргэнд 6,2 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт олгосон байна.

УБГ-аас сар бүр нас барсан, шилжсэн иргэдийн жагсаалтыг авч программ дээр тулгалт хийж байна. 10-р сарын байдлаар 4105 иргэнд 393,4 сая.төгрөгийн олголт хийгдсэн байна.

Халамжийн сан болон цалинтай ээжийн асуудлаар биечлэн ирж уулзсан 27 /үүнээс өргөдөл 6/, утсаар холбогдсон 16 хүний асуудалд хариу өгч шийдвэрлэсэн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын чиглэлээр:

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

- Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас гавъяаныхаа амралтад гарсан ахмадууд болон хүүхдийн байгууллагад ажиллаж байсан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.
- Боловсролын байгууллагын ойн арга хэмжээний хүрээнд Жаргалант кино театрын заланд багш нарын эрдэм шинжилгээний бага хурал болон багш сурагчдын уулзалт зохион байгуулагдлаа.
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 3-р улирлын ажлын тайлан бэлтгэж агентлагруу хүргүүллээ.
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Азийн хөгжлийн банк хамтран зохион байгуулсан Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагын албан хаагчдыг чадваржуулах бүсийн сургалтад байгууллагын нийт 10 албан хаагч 2019 оны 10 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд оролцлоо.

- Аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрт Байгууллагын үйл ажиллагааг танилцуулан оролцлоо.
- 2019 онд Булган аймгийн сумдын наадамд хурдан морь унасан нийт хүүхдийн мэдээллийг нэгтгэж Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлжээ. Энэ онд 3434 хурдан морь уралдаж, 1044 уралдаанч хүүхэд оролцсоноос 18 хүүхэд мориноос унаж 7 нь хөнгөн гэмтэл авсан байна.

Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр:

- Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 4 этгээдэд бүлгийн сэтгэл зүй буюу анги хамт олонтойгоо харилцах урлаг сэдвээр сургалт хийсэн. Мөн эдгээр хүүхдүүдийн хүмүүжлийн явцын талаар эцэг эхчүүд, цагдаагийн ажилтанд мэдээлэл хийсэн. 3-р сургуулийн нийгмийн ажилтны хүсэлтээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан сурагч Ням-Очир болон эцэг эхтэй сэтгэл зүйч уулзлаа.
- Амин хүүхэд ТББ-ын тэтгэлэгт хамрагдсан Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Сэлэнгэ сумдын нийт 17 хүүхдийн мэдээллийг Амин хүүхэд ТББ-т илгээж хүүхдүүд сар бүрийн тэтгэлгээ авч эхэлсэн.
- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимын үйл ажиллагаа тогтмол явагдаж байна. Энэ сард 2 насанд хүрэгч сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ авсан байна.
- Булган сумын 1-р сургуулийн эцэг эхийн зөвлөлийн 22 хүнд байгууллагын үйл ажиллагаа, сэтгэл зүйн үйлчилгээ, хүүхэд хамгаалал, хүүхдийн оролцооны сэдвээр сургалт, танилцуулга хийж ажиллаа.
- Булган сумын 1-р 10 жилийн сургуулийн дотуур байрны сурагчдын өгсөн өргөдөл гомдлын талаар тус байрны 112 хүүхэдтэй бүлгийн ярилцлага хийсэн
- Гэр бүлийн боловсролын цахим хичээлийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан цахим сүлжээнд байршуулан иргэдэд хүргэж байна. Энэ сард “Эрчүүд эмэгтэйчүүдээс юу хүсдэг вэ”, “Эцэг эхчүүдэд анхааруулга” сэдэвтэй 6 хичээлийг байршуулсныг 600 гаруй хүн үзэж сонирхсон байна.
- Монгол улсын их сургуулийн багш нар Булган сумын ЕБС-ын ахлах ангийн сурагчдад мэргэжлээ хэрхэн сонгох талаар лекцийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үзвэрийн танхим зохион байгууллаа. Тус лекцэд Булган сумын ерөнхий боловсролын 3 сургуулийн 100 гаруй сурагчид оролцлоо.

Хүүхэд залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:

- Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн “Хандлагаа өөрчилъе – Тэгш оролцъё” өдөрлөгийн зохион байгуулж Булган аймгийн 10 сумын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөөлөл 50 хүүхдүүд, тэдний эцэг эх 30 хүнийг оролцууллаа. Өдөрлөгт Хөгжлийн бодлогын хэлтэс, Боловсрол соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Төв эмийн сан зэрэг байгууллагууд хамтран оролцож хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, витаминжууллаа.
- Ø “Уран жиргээ” аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж 14 сумын 17 сургуулийн 60 гаруй хүүхэд, СӨБ, бага, дунд, ахлах анги гэсэн 4 насны ангиллаар оролцож өөрсдийн авьяас чадварыг сорилоо. Шалгарсан хүүхдүүд 10 дугаар сарын 23-ны өдөр улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцоод ирлээ.
- Ø Амьдрах ухааны сургалтыг Булган сумын 12 жилийн сургуулийн дотуур байрны сурагчдад хийхээр төлөвлөсний дагуу эмэгтэй дотуур байрны 65 сурагчдад мэргэжил сонголтын сургалтыг зохион байгууллаа.
- Ø “ҮЛГЭРЧ ААВ” арга хэмжээг аймгийн Эрүүл мэндийн газар, төв номын сантай хамтран Булган сумын 6 цэцэрлэгийн Бэлтгэл бүлгийн 291 хүүхдэд зохион байгууллаа. Тус үйл ажиллагаагаар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн аав, ээжийн төлөөллөөс хүүхдүүдэд үлгэр уншиж өгөн, ач холбогдол, үлгэрийн үйл явцыг багачуудтай хамт ярилцлаа. Арга хэмжээний үеэр Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн амны хөндийн ариун цэвэр, шүдээ хэрхэн угаах талаар үзүүлэн сургалт зохион байгуулж ажиллалаа.

- Ø Булган сумын төрийн байгууллага, аж ахуйн нэгжид гэр бүлээрээ ажилладаг залуусын дунд “Ханьтайгаа хамтдаа” тэмцээнийг зохион байгуулж байна. Эхний шатны тэмцээнийг Аймгийн Цагдаагийн газарт зохион байгуулж гэр бүлийн боловсрол сургалт зохион байгуулж оролцогч хосыг сонголоо.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Мал аж ахуйн чиглэлээр:

Сумдын хэмжээнд 1600 тн өвс бэлтгэхээс 66,1 хувь буюу 1058 тн өвс сумын нөөцөд бэлтгэсэн байна. Дутагдах 542 тн өвсийг худалдан авахаар бэлтгэл ажил хийж байна. Тэжээл 480 тн бэлтгэхээс 58 хувь буюу 277 тн нөөцөд бэлэн байгаа бөгөөд дутагдах тэжээлийг “Булганхангай” ХХК-иас авахаар төлөвлөсөн.

Малчдын хэмжээнд 88.5 мянган тн байгалийн хадлан, 1.2 мянган тн ногоон тэжээл, 8.4 мянган тн үйлдвэрийн тэжээл, 1.6 мянган тн гар тэжээл, 8.2 мянган тн давс хужир шүү бэлтгэхээс одоогийн байдлаар өвс 88404 тн, сүрэл 2022 тн, ногоон тэжээл 4456 тн, үйлдвэрийн тэжээл 4448 тн, гар тэжээл 1434 тн-ийг бэлтгэсэн нь аймгийн хадлангийн төлөвлөгөөг 100 хувь бэлтгээд байна.

Аймгийн хэмжээнд 2019-2020 оны мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг 87.2 хувиар хангаад байна. Малчдын өвс, тэжээл бэлтгэл 89.5%, аймгийн аюулгүйн нөөцийн бэлтгэл 77.5%, сумын аюулгүйн нөөцийн бэлтгэл 72.6%, худгийн бэлэн байдал 89.9%, малын усан хангамж 92,6%, малчин өрхийн хашаа, бууцны хангамж 95.8%, малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэл 92.8% -иар тус тус хангагдлаа.

Баян-Агт, Бугат, Тэшиг, Хангал, Сэлэнгэ сумд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг 90.3-99.5%-иар хангаж, сайн зохион байгуулсан байна.

ХХААХҮ-н сайдын А/303 дугаар тушаалаар “Үлийн цагаан оготнойтой байгальд хоргүй аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулах тухай”, аймгийн Засаг даргын А/506 дугаар захирамжаар Дашинчилэн 10.0 га, Рашаант 10.0 га, Гурванбулаг 10.0 га, Могод 5.0 га, Хишиг-Өндөр 5.0 га, Сайхан 10.0 га буюу нийт 50000 га бэлчээрийн талбайд тэмцлийн ажлыг энэ оны 10 дугаар сарын 25-аас 11 дүгээр сарын 15-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулж байна.

Шинэ хөдөө” /Булган/ төслийн тендер шалгаруулалтын 1, 2, 3, 4, 5, 6, 14 дүгээр багцад үнийн санал ирээгүй, 13, 15, 17, 18 дугаар багцад ирсэн тендерийн материал шаардлага хангаагүй тул тендерийг дахин зарласан боловч 1, 2, 3, 4, 6, 14, 13, 17, 18 дугаар багцууд дахин шаардлага хангасан тендерийн материал ирээгүй тул дээрх багцуудад хуульд тусгагдсаны дагуу бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулах аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, “Газар агро”, “Алтан бичигт цахт”, “Хужирын адаг” “Шинэ хөдөө-Булган” төслийн хүрээнд “Газар агро” ХХК-тай шууд гэрээ байгуулан Геррефорд үүлдрийн 15 толгой, Геррефорд Сэлэнгэ үүлдрийн 1 дүгээр үеийн эрлийз 35 толгой өсвөр бухыг шилэн сонгох ажлыг хийлээ.

Орон нутгийн төсвөөр Баян-Агт, Сайхан сумдад гаргаж буй инженерийн хийцтэй худгийн гүйцэтгэлд хяналт тавьж, эрчимжүүлэх үүрэг өгсөн.

Хүнс, газар тариалангийн чиглэлээр:

Монгол улсад Атар газар эзэмшиж, газар тариалангийн үйлдвэрлэлийг бие даасан салбар болгож хөгжүүлсний 60 жилийн ойн арга хэмжээг төлөвлөгөөг батлуулан, ажлын хэсэг томилон бэлтгэл хангаж байна.

Ургац хураалт Рашаант, Хутаг-Өндөр сумаас бусад дууссан 96,9 хувьтай байна. Үр тариа 52314 тн, төмс 4112 тн, хүнсний ногоо 872 тн хураан авсан.

Улаанбаатар хотод зохион байгуулсан “Айрагны баяр 2019” арга хэмжээнд байгууллагын дарга, хүнсний мэргэжилтэн, бичиг хэрэг, жолоочийн хамт 2 өдөр томилолтоор ажиллаж, “Айраг тааваар уу” үйлчилгээний гэр, Баян-Агт сумыг хариуцан бэлтгэл хангуулж, “Хэн сайн айраг уух вэ” тэмцээнүүдийг зохион байгуулж ажилласан.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяны тайланг сумдаас болон бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдээс ажлын хэсгийнхнээр дамжуулан авч нэгтгэж байна. ХХААХҮЯ-нд аяны тайланг урьдчилсан байдлаар хүргүүллээ. 11 дүгээр сарын 04-нд ажлын хэсэг хуралдаж шалгаруулалтаа хийнэ.

“Намрын ногоон өдрүүд Булган үйлдвэрлэв-2019” үзэсгэлэн худалдаанд Ханжаргалант худалдааны төвд 12 сум 1 тосгоны жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн 18 нэр төрлийн бүтээгдэхүүн оролцож 14 шилдэг номинац шалгаруулсан байна. үзэсгэлэн худалдаанд “Герефорд” үүлдрийн бух 2, “Сэлэнгэ” үүлдрийн бух 2, “Хангай” үүлдрийн хонь 3, Баяд үүлдрийн хуц 8, эрчмийн хар ухна 2 нийт 17 мал оролцсон байна.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Бугат сумын 1-р багийн шандад өвөлжиж байгаа Д.Нүржигдуламын үхэрт боом өвчин оношлогдож сумын Засаг даргын 2019-оны 10-р сарын 04-ны өдрийн А/135 тоот тушаалаар хорио цээрийн дэглэм тогтоон ажилласан. Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамрагдах малын тоог гарган МЭЭГ-аас 5,4 литр боомын вакциныг татан авч өвчний голомтын болон гадна талын сэжигтэй, хамгаалалтын бүсийн 44 өрхийн 1558 бод, 11422 бог мал нийт 12980 малыг вакцинд хамруулсан. Сумын Засаг даргын 10 дугаар сарын 17-ний өдрийн А/137 тоот захирамжаар хорио цээрийн дэглэмийг цуцалсан.

Монгол мал хөтөлбөрийн хүрээнд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд энэ оны охин төлийг хамруулж гүйцэтгэлийн баримтыг хүлээн авч нэгтгэн УМЭЭГ-т хүргүүлсэн. Тус ажилд нийт 4,292 өрхийн 51,2 мянган толгой тугал, 796,9 мянган толгой хурга, ишиг буюу нийт 848,2 мянган толгой төл мал хамруулж 94,1 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

Мөн улсын болон, орон нутгийн төсвөөр хийгддэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын гүйцэтгэлийг авч шалгаж байна. Орон нутгийн төсвөөс 18 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 24,0 сая төгрөгний санхүүжилт олгосон.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээ, мал эмнэлгийн ажил үйлчилгээний талаар Бугат, Орхон, Сэлэнгэ сумдад мониторинг хийж малчидтай уулзаж мал эмнэлгийн ажлын хүртээмж, чанарын талаар санал хүсэлт, сэтгэгдэлийг сонсож ажилласан.

ТАВ: БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгаль орчны чиглэлээр:

Бүрэгхангай сумын 10, Сэлэнгэ сумын 1 уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн биологийн нөхөн сэргээлт 95,4 га, техникийн нөхөн сэргээлт 96,4 га талбайг урьдчилсан байдлаар хүлээн авч танилцлаа.

Бүх нийтээр мод бут тарих ажлыг 10 дугаар сарын 05-нд зохион байгуулж, Булган суманд үйл ажиллагаа явуулж буй 57 байгууллагын 340 гаруй хүн оролцож, Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн, Сансар, Төгсөгчдийн саданд 476 ширхэг мод бутыг тарилаа.

"НОГООН ПАСПОРТ-НОГООН ТӨГӨЛ" модлог ургамлын цэцэрлэгт хүрээлэнгийн нээлтийн үйл ажиллагаа боллоо.

Нээлтэд БОАЖЯ-ны ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн дарга Н.Батзаяа, Булган аймгийн ЗДТГ, БОАЖГазар, Ус цаг уур орчны шинжилгээний газар, Хануй голын сав газрын захиргаа, сум дундын ойн анги, ерөнхий боловсролын сургуулийн 200 гаруй сурагчид оролцож, 11 зүйлийн 500 ширхэг тарьцыг тарилаа.

Уг арга хэмжээнд орчны бүсийн Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумдын ерөнхий боловсролын сургуулийн төлөөлөл 1 багш, 7 сурагч хамрагдан ногоон паспорт эзэмшигч болов.

ИТХ-ын ажлын албанаас 13 хүний хүний бүрэлдэхүүнтэйгээр Бүрэгхангай, Дашинчилэн сумдад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, ус, газрын төлбөрийн гүйцэтгэл, шаардлагатай бичиг баримтын бүрдлийг шалгах, уул уурхайн бодлогын баримт бичиг боловсруулахтай холбоотойгоор тэдний санал бодлыг сонсох зорилгоор 2019 оны 10 дугаар сарын 09-12-ны хооронд хяналт шалгалтын ажлыг хийлээ. Тус шалгалтаар Эко алтан заамар, Хоту, Платинум ланд ХХК-иуд болон Ханжаргалант нутаг нөхөрлөлөөр орлоо.

Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газартай хамтран Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, сумдад хамтарсан хяналт шалгалтыг зохион байгууллаа. Уг шалгалтаар 50 ширхэг тарвага тээвэрлэж явсан 60 ширхэг загас, 1 ширхэг хярс зохих эрхийн бичиггүйгээр агнасан зөрчлийг илрүүлж 19.550.0 мянган төгрөгийн торгууль нөхөн төлбөрийн арга хэмжээ авсан.

Нөхөрлөлүүдийн ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн “Мөнх ногоо жодоо” ХХК тайлангаа ирүүллээ. АТГ-ын сургалтад мэргэжилтнүүд хамрагдаж, усны нөөцийн зөвлөгөөнд оролцсон.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

Булган аймгийн Орхон, Бугат, Тэшиг, Хутаг-Өндөр, Тэшиг, Хишиг-Өндөр, Дашинчилэн сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер зарлагдаж мэргэжлийн “Вектор мэл” ХХК шалгарч аймгийн Засаг даргын А/386 дугаар захирамжаар ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Хангал, Дашинчилэн, Хишиг-Өндөр сумын нутаг дэвсгэрт хээрийн тодруулалтыг хийж сумын иргэд болон багийн Засаг дарга нараас санал авч суурин боловсруулалтын ажилд сумдын удирдлагуудаас тодруулга авах ажлыг 10 сараас эхлэн гүйцэтгэж, төлөвлөгөөний төслийг боловсруулан багийн ИНХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна. Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн сумын ИТХ-р хэлэлцүүлэн 9/03 дугаар тогтоол, Орхон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2019 оны 08/07 дугаар тогтоолоор тус тус баталгаажууллаа. Тэшиг сумын ажлыг 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн ИТХ-р хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.

Булган аймгийн Сайхан, Архангай аймгийн Хайрхан сумтай газар нутгийн маргаан үүсч сум орон нутгийн зүгээс шийдвэрлэх боломжгүй тул уг асуудлыг шийдвэрлэж өгөх талаар аймгийн Засаг даргын албан хүсэлтийг хүргүүлсний дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн А/213 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр газар дээр нь ажиллах явцад манай аймгийн 1:100 000 машстбатай байр зүйн зурагт тэмдэглэгдсэн “Өргөөт” уул нь “Мэргэн”, “Есөн модот” уул нь “Өргөөт” уул хэмээн нэрлэдэг гэж 2 аймгаас ажлын хэсэгт орсон орон нутгийн хүмүүс нотолж АИХ-ын тэргүүлэгчдийн зарлигаар баталсан хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэршлийг буруу нэршлээр орсон тул солиулах саналаа холбогдох журмын дагуу хүсэлтээ өгөх эрх нээлттэй байгаа талаар сум орон нутгийн удирдлагуудад зөвлөгөө өгөв. Мөн газар нутгийн нэрийн зургийг буруу нэршлээр АИХ-ын зарлигт тусгасан боловч хилийн цэсийн шугамыг 1945 оны анх хилийн цэсийг зурагласан зургийг одоо мөрдөгдөж буй 2 аймгийн хилийн зурагтай давхардуулан шалган үзэхэд анх тогтоосон хилээр байгаа тул сум орон нутгийн иргэдэд хилийн шугамын хувьд зөрүү байхгүй харин газар нутгийн нэршлийг буруу нэрлэсэн байна гэдэг ойлголтыг өгч ажиллаа.

Багийн хилийн заагийг тодорхойлох суурин судалгаа болон хээрийн хэмжилтийн ажлыг хянах, 2019 оны газрын даамлын үйл ажиллагаанд дотоод хяналт

шалгалт хийх, зөвлөн туслах ажлаар Бүрэгхангай, Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Баяннуур, Могод, Хишиг-Өндөр, Орхон суманд 2019 оны 10 дугаар сарын 14-22-ны өдрүүдэд ажиллаа.

Газар өмчлөлийн чиглэлээр:

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь “Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх” гэрээт ажлын хүрээнд Газрын кадастрын мэдээллийн сан дахь газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн нэгж талбар бүрийг улсын бүртгэлтэй тулган шалгаж байна. Газрын кадастрын мэдээллийн сан дахь газар өмчлөгчийн бүртгэлийг шалгахад газар өмчлөгчөөр аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн, өмчлөгч эзэн тодорхойгүй, зориулалт буруу зэрэг асуудлууд гарч байгаа нь газрын татварын ногдуулалтыг Татварын удирдлагын системд илгээхэд хүндрэл учруулж байна. Иймд газрын даамлууд Газар өмчлөлийн улсын бүртгэлийг Газрын кадастрын мэдээллийн сантай тулган, хавсралт дахь хүснэгтийн дагуу судалгааг гарган ирүүлэх тухай 2019 оны 01/653 дугаар албан тоотыг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

Хишиг-Өндөр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан шинэ суурьшлын бүс үүсэх гэр хорооллын бүсчлэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 36 айлын эргэлтийн цэгийг тодорхойлж тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгэлээ.

Газрын кадастрын чиглэлээр:

Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын татвар, төлбөрийн мэдээлэл Татварын мэдээллийн санд холбогдох болсонтой холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын судалгааг Лэнд менежер програмд бүртгэгдсэн нэгж талбартай нэг бүрчлэн тулгаж, шалгах, засварлах ажлыг 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор хийж гүйцэтгэх шаардлагатай байгаа тул 2019 оны 01/632 албан тоотоор сумдад чиглэл хүргүүллээ. Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн биелэлт, ГЗБГЗЗ-аас байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг хугацаанд нь гарган хүргүүллээ.

10 дугаар сарын 18, 19-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулж, авч хэрэгжүүлж буй ажлын талаар сонирхсон иргэд, байгууллагуудад мэдээлэл өгч, байгууллагын ажил, үйлчилгээтэй холбоотой санал асуулгын хуудас бөглүүлэн, санал хүсэлтийг сонсон 2019 оны газрын төлбөрийн нэхэмжлэхийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад өгч газрын төлбөрийн орлогыг бүрдүүлэх тал дээр нэлээд ач холбогдол өгч ажиллаа.

Инженерийн шугам сүлжээ бүхий газрын чиглэлээр:

Булган сумын инженерийн шугам сүлжээ бүхий газартай холбогдолтой 14 өргөдөл ирснээс аймгийн Засаг даргын 2019 оны а/493 дугаар захирамжаар 1 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж, а/473, 494 дүгээр захирамжаар 6 иргэний газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэн, Улсын бүртгэлийн дугаар авч гэрчилгээ шинэчлэх 3 өргөдөл ирснийг шийдвэрлэн гэрээ, гэрчилгээг шинэчлэн олголоо. Шинээр газар эзэмшихийг хүссэн 2 өргөдөл, өмчилсөн газрын хэмжээг өөрчлүүлэхийг хүссэн 2 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд байна.

Инженерийн шугам сүлжээ бүхий газрын өмчлөл, эзэмшилд олгогдсон нэгж талбаруудыг газрын улсын бүртгэл болон газрын төлбөрийн ГТМ-4 маягттай нэг бүрчлэн тулгалт хийн засварлах ажлыг хийж байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Газрын тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн газар эзэмших эрхээ бусдад шилжүүлсэн 3 иргэний орлогын татвар болох 255 840 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/468 тоот “Өвөлжилтийн бэлтгэл шалгах ажлыг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу Гурванбулаг, Рашаант сумдад

ажиллаа. Дээрх хоёр суманд мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийт сумдад хадлан тэжээл бэлтгэлийг чанартай зохион байгуулсан байдал, худаг уст цэгийн ашиглалт, хашаа хорооны хангамжийг сайжруулах мал эмнэлгийн үйл ажиллагааг технологийн хугацаанд нь дуусгах, эр сувай малыг борлуулж байгаа байдалтай танилцаж, төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг газар дээр явж танилцан холбогдох байгууллагын дарга, эрхлэгчид мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч ажиллаа.

Барилга угсралт:

“Заг инженеринг” ХХК-ийн гүйцэтгэж буй цэвэрлэх байгууламжийн ажил нь одоогоор нийт барилгуудын цутгалт + 0,00 түвшнээс дээш гарсан биологи цэвэрлэгээ болон үйлдвэрийн барилга, лагийн талбай хоорондын шугамын холболт, 400*2 КВт-ын цахилгааны дэд станц, захиргаа аж ахуйн барилгуудын тоосгон өрлөг, төв шугамын насос станцын суурийн цутгалтын ажлууд хийгдэж байна. Хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан технологийн горимд өөрчлөлт орж байна, мөн зогсоох шаардлагатай үе шатны ажлын процесс хэрхэн явагдах, ямар хамгаалалтын арга хэмжээ авч ажиллах талаар гүйцэтгэгч инженерүүдтэй зөвшилцөж хийж хэрэгжүүлэх шаардлагатай ажлын талаар зөвлөсөн. Мөн зарим нэг алдаа дутагдалтай байгаа ажлуудыг засаж залруулах үүрэг чиглэлийг өгсөн.

Булган аймгийн Тэшиг сумын 25 хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг “ДШТД” ХХК гүйцэтгэсэн бөгөөд ашиглагчийн хүсэлтийг хүлээж авч нэмэлт ажлуудыг хийсэн байна. Засварын ажил чанартай хийгдсэн, комиссын гишүүдийн 100 хувийн саналаар барилгын ажлыг байнгын ашиглалтад хүлээж авсан.